



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 04

Өмнөдэлгэр сум

2025 онд үйлдвэрлэлийн болон арчилгаа,
цэвэрлэгээний огтлолтоор ойгоос мод бэлтгэх
дээд хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.3, 32.3.1, 32.3.2 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Дөрөвдүгээр хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Сумын ойн сангаас 2025 онд мод бэлтгэх ойн мэргэжлийн байгууллагуудын модны дээд хязгаарыг огтлолт, модны төрлөөр хавсралтаар баталсугай.

2.Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж бэлтгэсэн модныхоо 100м³ тутамд 2.0 га-д, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бэлтгэсэн модныхоо 100м³ тутамд 1.0 га-д, ойн цэвэрлэгээний ажлаар ойгоос мод бэлтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага бэлтгэсэн хэрэглээний модныхоо 100м³ тутамд 0.5 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, тайланг хагас жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр), Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга (Г.Мөнх-оргил) нарт даалгасугай.

3.Ойн мэргэжлийн байгууллагууд хуваарилсан нийт модны 30%-ийг сумын иргэдийн ахуйн хэрэглээний байшин, малын хашаа, саравч барих, түлшний модны хэрэгцээнд зарцуулж тайланг хагас жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг мод бэлтгэх эрх авсан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн захирал нарт үүрэг болгосугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороо, хорооны дарга (Д.Энхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
 Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны
 өдрийн ээлжит Дөрөвдүгээр хуралдааны
 04 дүгээр тогтоолын хавсралт
 2025 онд Өмнөдэлгэр сумын ойн сангаас ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэх дээд хязгаар
 /огтлолтын төрөл болон модны төрлөөр/



№	Ойн мэргэжлийн байгууллагын нэр	Модны төрөл	Огтлолтын төрөл																Бүгд дүн /м3/	Нийт өөрийн хөрөнгийн ойжуулалт /га/				
			Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор					Арчилгааны огтлолтоор					Цэвэрлэгээний огтлолтоор					Цэвэрлэгээний ажлаар						
			Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн ойжуулалт /га/	га	Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн ойжуулалт /га/	га	Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн ойжуулалт /га/	га							
1	Модон цаг ХХК	Шинэс	231	69	300	6.0	20	70	23	93	0.93	6	467	700	1167	11.7	58			1560	18.6			
		Дүн	231	69	300	6.0	20	70	23	93	0.93	6	467	700	1167	11.7	58			1560				
2	Зоос булаг ХХК	Шинэс	231	69	300	6.0	20	70	23	93	0.93	6	467	700	1167	11.7	58	210	350	560	2120	19.6		
		Дүн	231	69	300	6.0	20	70	23	93	0.93	6	467	700	1167	11.7	58	210	350	560	2120			
3	Их баян дуурлиг ХХК	Шинэс	238	72	310	6.2	21	70	24	94	0.94	6	466	700	1166	11.7	58.3				1570	19.2		
		Хус						30	10	40	0.4									40				
4	Өгөөмөр сайхан хангай ХХК	Дүн	238	72	310	6.2	21	100	34	134	1.34	6	466	700	1166	11.7	58.3				1610			
		Шинэс	140	42	182	3.6	12													182	3.6			
	Нийт дүн	Дүн	140	42	182	3.6	12													182	3.6			
			840	252	1092	21.8	72.8	240	80	320	3.2	19	1400	2100	3500	35	175	210	350	560	5472	61.1		